



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алдархаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/145/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улиастай сум  
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа  
Утас: 99993365  
Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)  
Аудитын менежер: Х.Болдбаатар  
Утас: 99105506  
Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)  
Хаан соёмбо аудит ХХК -гэрээт аудитор:  
Б.Цэрэндэжид  
Утас: 99812811  
Цахим хаяг: [tserendejid1109@gmail.com](mailto:tserendejid1109@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улаанбаатар, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.21 № 186  
танил -ны № -г

АЛДАРХААН СУМЫН  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Ч.ИЧИНХОРЛОО-Д

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алдархаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алдархаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Алдархаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 76 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 90.5 хувьтай дүгнэгджээ. Алдархаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2024 онд улсын төсвөөс 350,002.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 22,448.3 мянган төгрөгийн санхүүжилттэй, 69,784.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

#### Аудитын гол асуудал

Алдархаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртөө бүрэн нөхсөн 55 нэр төрлийн 51,226.4 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж, ашиглах хугацааг сунгаагүй, хүүхдийн хоолыг норматив зардлаас 1,834.6 мянган төгрөг илүү олгосон, хүнсний материалын үлдэгдэл 2,393.3 мянган төгрөгөөр дутагдсан байна.

#### Бусад асуудлын хэсэг

Алдархаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь Боловсролын ерөнхий газрын хөрөнгө

D/disk/Албан бичиг/Дүгнэлт

81057070

оруулалтаар 5,674.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

---

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	76,752,345.08	134,725,921.52
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДЛЛГАХ ХӨРӨНГӨ	22,587,513.42	69,784,273.86
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	22,587,513.42	69,784,273.86
3121	Төгрөг	22,587,513.42	69,784,273.86
31211	Төрийн сангийн харилцах	22,587,513.42	69,784,273.86
35	БАРАА МАТЕРИАЛ	54,164,831.66	64,941,647.66
354	Хангамжийн материал	54,164,831.66	64,941,647.66
35410	Бичиг хэргийн материал	967,180.00	1,106,680.00
35420	Аж ахуйн материал	2,201,850.00	11,950,400.00
35450	Барилгын засварын материал	750,000.00	750,000.00
35460	Хүнсний материал	10,040,435.00	10,961,886.00
35470	Бусад хангамжийн материал	40,205,366.66	40,172,681.66
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	654,954,065.61	640,478,330.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	654,954,065.61	640,478,330.53
392	Биет хөрөнгө	648,766,565.61	634,455,830.53
39201	Барилга, байгууламж	681,438,854.00	681,438,854.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(51,575,521.04)	(65,345,520.88)
39205	Машин, тоног төхөөрөмж	61,269,573.30	66,943,813.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(48,299,481.15)	(53,456,339.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,981,160.70	13,981,160.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,468,358.20)	(10,626,474.73)
39217	Номын фонд	1,420,338.00	1,520,338.00
393	Биет бус хөрөнгө	6,187,500.00	6,022,500.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хасагдуулга	(1,072,500.00)	(1,237,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,610,000.00	5,610,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	731,706,410.69	775,204,252.05
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	630,600.01	2,125,393.31
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	630,600.01	2,125,393.31
413	Өглөг	630,600.01	2,125,393.31
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.01	-
4136	Бусад өглөг	630,600.00	2,125,393.31
41361	Байгууллагад төлөх өглөг	630,600.00	2,125,393.31
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	731,075,810.68	773,078,858.74
51	Засгийн газрын хувь оролцоо	731,075,810.68	773,078,858.74
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	35,271,362.87	35,271,362.87
51101	Өмч: -Төрийн өмч	35,271,362.87	35,271,362.87
512	Хуримтлагдсан үр дүн	694,944,819.81	736,947,867.87
51210	Өмнөх үеийн үр дүн	694,944,819.81	694,944,819.81
51220	Тайлант үеийн үр дүн	-	42,003,048.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	859,628.00	859,628.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	731,706,410.69	775,204,252.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	274,303,356.00	383,124,740.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,241,556.00	10,674,240.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,241,556.00	10,674,240.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	-	5,674,240.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого	-	5,000,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	6,241,556.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,091,556.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	268,061,800.00	372,450,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	236,392,600.00	350,002,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	236,392,600.00	350,002,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,669,200.00	22,448,300.00
132001		31,669,200.00	22,448,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	262,683,619.74	340,874,006.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	262,683,619.74	340,874,006.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	262,660,044.30	340,034,006.94
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	162,924,515.00	233,451,375.00
210101	Цалин	94,580,837.00	147,794,649.00
210102	Нэмэгдэл цалин	63,079,688.00	80,501,796.00
210104	Урамшуулал	5,263,990.00	5,154,930.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,922,110.12	30,835,784.55
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	14,417,129.52	21,361,654.74
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,626,245.15	2,448,742.44
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,300,996.12	1,873,437.15
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	325,249.03	468,359.34
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,252,490.30	4,683,590.88
2103	Байр ашиглалттай холбоотой төгтмол зардал	27,963,143.78	22,573,693.31
210301	Гэрэл цахилгааны зардал	2,827,174.98	3,017,796.31
210302	Түлш, халаалтын зардал	25,135,968.80	19,555,897.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,414,800.00	4,413,730.00
210401	Бичиг хэргийн материал	1,311,850.00	1,305,600.00
210402	Тээвэр, шатахууны зардал	979,000.00	1,257,380.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	2,123,950.00	1,850,750.00
2105	Нормативт зардал	21,784,455.00	22,915,959.00
210502	Хоол	21,784,455.00	22,915,959.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,505,000.00	1,160,000.00
210604	Урсгал засвар	1,505,000.00	1,160,000.00
2107	Томилолт, зочны зардал	224,000.00	-
210702	Дотоод томилолтын зардал	224,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	535,900.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	535,900.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,386,120.40	24,683,465.08

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,871,300.00	4,433,490.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,514,820.40	20,249,975.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,575.44	840,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,575.44	840,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,575.44	840,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-III)	11,619,736.27	42,250,733.06
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	247,685.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	247,685.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	(247,685.00)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	11,619,736.27	42,003,048.06

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	268,211,800.00	372,450,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	150,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	150,000.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	150,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	268,061,800.00	372,450,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	236,392,600.00	350,002,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	236,392,600.00	350,002,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,669,200.00	22,448,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,669,200.00	22,448,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	244,988,672.58	325,153,739.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	244,988,672.58	325,153,739.56
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	244,965,097.14	324,313,739.56
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	161,275,530.59	230,560,459.56
210101	Үндсэн цалин	114,443,453.38	144,903,733.56
210102	Нэмэгдэл	41,006,487.21	80,501,796.00
210104	Үр дүнгийн урамшуулал	5,825,590.00	5,154,930.00
2102	Ажил олгогчоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	22,447,899.99	33,726,700.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	15,264,599.99	22,934,100.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,796,000.00	2,698,100.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,436,400.00	1,349,100.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	359,100.00	1,349,100.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,591,800.00	5,396,300.00

2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	29,669,200.00	20,448,300.00
210301	Гэрэл цахилгааны зардал	2,717,750.42	3,017,796.31
210302	Түлш, халаалтын зардал	26,451,449.58	16,971,803.69
210303	Цэвэр, бохир усны зардал	500,000.00	458,700.00
2105	Нормативт зардал	20,283,742.00	24,038,110.00
210502	Хоол, хүнс	20,283,742.00	24,038,110.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,976,424.56	1,160,000.00
210604	Урсгал засвар	1,976,424.56	1,160,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	535,900.00	412,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	535,900.00	412,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,776,400.00	13,967,670.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,178,750.00	10,847,370.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дэдлаг хийх	1,597,650.00	3,120,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,575.44	840,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох тагаас, санхүүжилт	23,575.44	840,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,575.44	840,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	23,223,127.42	47,296,760.44
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	23,223,127.42	47,296,760.44
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	333,491.00	22,587,513.42
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,587,513.42	69,784,273.86

#### 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
2	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	29661362.87	2297148	16089703.69	48048214.56
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29661362.87	2297148	16089703.69	48048214.56
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	7480565.08	7480565.08
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	35271362.87	859628	694944819.8	731075810.7
10	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	35271362.87	859628	694944819.8	731075810.7
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35271362.87	859628	694944819.8	731075810.7
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	42003048.06	42003048.06
18	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	35271362.87	859628	736947867.9	773078858.7

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	22,587,513.42	(22,587,513.42)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	371,808,800.00	302,805,439.56	69,003,360.44	81.44
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	371,808,800.00	302,805,439.56	69,003,360.44	81.44
210	Бараа, үйлчилгээний зардал	371,808,800.00	302,805,439.56	69,003,360.44	81.44
2101	Цалин хөлс боловч нэмэгдэл урамшил	294,906,500.00	230,560,459.56	64,346,040.44	78.18
210101	Үндсэн цалин	200,036,800.00	144,903,733.56	55,133,066.44	72.44
210102	Нэмэгдэл	92,190,800.00	80,501,796.00	11,689,004.00	87.32
210104	Урамшуулал	2,678,900.00	5,154,930.00	(2,476,030.00)	192.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,735,300.00	33,726,700.00	1,008,600.00	97.10
210201	Тэтгэврийн даатгал	23,620,500.00	22,934,100.00	686,400.00	97.09
210202	Тэтгэмжийн даатгал	2,778,300.00	2,698,100.00	80,200.00	97.11
210203	ҮОМШӨ ний даатгал	1,389,400.00	1,349,100.00	40,300.00	97.10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,389,400.00	1,349,100.00	40,300.00	97.10
210205	Эрүүл мэндийн даатгал	5,557,700.00	5,396,300.00	161,400.00	97.10
2105	Нормативт зардал	25,290,800.00	24,038,110.00	1,252,690.00	95.05
210502	Хоол, хүнс	25,290,800.00	24,038,110.00	1,252,690.00	95.05
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	893,500.00	412,500.00	481,000.00	46.17
210806	Мэдээллийн технологийн зардал	893,500.00	412,500.00	481,000.00	46.17
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	15,982,700.00	14,067,670.00	1,915,030.00	88.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,860,400.00	10,947,370.00	1,913,030.00	85.12
210902	Хячээл үйлдвэрлэлийн дадлага хийх ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,122,300.00	3,120,300.00	2,000.00	99.94
		371,808,800.00	350,002,200.00	21,806,600.00	94.13
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	350,002,200.00	350,002,200.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ	350,002,200.00	350,002,200.00	-	100.00
120004	АЖИЛЛАГААНААС	21,806,600.00	-	21,806,600.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	21,806,600.00	-	21,806,600.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	22,587,513.42	(22,587,513.42)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	69,784,273.86	(69,784,273.86)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	9.00	9.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00

620002	Гүйцэтгэх ажилтан	5.00	5.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	63	63	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ДҮН	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,448,300.00	21,608,300.00	840,000.00	96.26
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	22,448,300.00	21,608,300.00	840,000.00	96.26
210	Бараа, үйлчилгээний зардал	22,448,300.00	21,608,300.00	840,000.00	96.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,448,300.00	20,448,300.00	-	100.00
210301	Гэрэл цахилгаан	1,804,900.00	3,017,796.31	(1,212,896.31)	167.20
210302	Түлш, халаалт	18,143,400.00	16,971,803.69	1,171,596.31	93.54
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	458,700.00	41,300.00	91.74
2106	Эд хогшил худалдан авах	2,000,000.00	1,160,000.00	840,000.00	58.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,160,000.00	840,000.00	58.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,448,300.00	22,448,300.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,448,300.00	22,448,300.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	22,448,300.00	22,448,300.00	-	100.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### Алдархаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэл:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох

Алдархаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн зорилго: Суралцагчийн эзэмших чадамж (танин мэдэхүй, эрүүл мэнд, нийгэм сэтгэл хөдлөл)-г хөгжүүлэхэд бүх талын оролцоо, хамтын ажиллагааг хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааны чанар үр дүнг сайжруулах зорилготой,

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 79 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

#### Алдархаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

**Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд орсон өөрчлөлт:** 2024 оны 03 сарын 27-ны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тотоосон, Боловсролын ерөнхий хууль 2024 оны 07-р сарын 07-нд батлагдсан. Засгийн газрын 2024 оны 08 сарын 28-ны 53 дугаар тогтоолоор "Хувьсах зардлыг хэмжээ, итгэлцүүр" шинэчлэгдэн батлагдсан, Сангийн Сайдын 2024 оны 04 сарын 01-ний А/52 тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан. Мөн Засгийн газрын 2024 оны 05 сарын 29-ний 237 дугаар тогтоолоор "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын эрхлэгч, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алдархаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**  
Алдархаан сумын СӨБ-н 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 43,497.6 мянган төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	54,164.8	64,941.6	10,776.8
Үндсэн хөрөнгө	654,954.1	640,478.3	14,475.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>731,706.4</b>	<b>775,204.3</b>	<b>43,497.9</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	35,271.4	35,271.4	0

Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	731,075.8	773,078.9	42,003.1
---------------------------------------	-----------	-----------	----------

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

#### Тайланд онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 54,164.8 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 34,354.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 5,000.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 28,577.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 64,941.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 10,776.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 100.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 5,674.2 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, жилийн эцэст 640,478.3 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 2,0250.0 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

#### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

##### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 350,002.2 мянган төгрөг, нийт зарлагыг 350,002.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, Засаг даргын нөөц хөрөнгийг тодотголоор нэмж баталсан байна.

##### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 350,002.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 22,448.3 мянган төгрөгний санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 324,413.7 мянган төгрөг буюу 82.3 хувьтай байна. Энэ нь цалин, ндш, мэдээлэл технологи,хоол хүнс, урсгал засвар, бусад бараа материалын зардлыг 69,841.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
71801	Сургуулийн өмнөх боловсрол				
80233	Хүүхэд хамгаалал	636.6	636.6	0.0	100%
81605	Эрүүл мэндийг дэмжих	1,311.2	993.0	318.2	75.7%
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	39,152.0	38,131.9	1,020.1	97.4%
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,923.0	1,923.0	-	100%
81823	Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	880.8	0.0	880.8	0%

81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	6,261.8	5,960.8	301.0	95.2%
81834	Боловсролын стандарт сургалтын орчин	438,166.8	378,213.6	59,953.2	86.3%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	7,491.7	7,491.7	0.0	100%
<b>Орон нутгийн төсвөөс</b>					
80109	ТЗШ-ийн байгууллагын тогтмол зардал	71,409.4	28,893.3	42,516.1	40.5%
<b>НИЙТ</b>		<b>567,233.3</b>	<b>462,243.9</b>	<b>104,989.4</b>	<b>81.5%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Худалдан авалтыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан.

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алдархаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Хаан соёмбо аудит” ХХК-ийн гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд анхан шатны хяналт хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Алдархаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 340,034.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6,800.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5,440.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Алдархаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно..

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 10,040.0 мянган төгрөгийн зөрчилд 1 заалт зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	10,040.0	1	10,040.0	100%
Нийт дүн	1	10,040.0	1	10,040.0	100%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хүүхдийн хоолны нормативыг мөрдөж ажиллах, амархан муудаж, чанар байдал нь алдагдах хүнсний бүтээгдэхүүнийг нөөцөлж, удаан хугацаагаар хадгалахгүй байх, эд хариуцагчийн гаргаж байгаа бараа материалын тайланг сар бүр хянаж, үлдэгдлийг баталгаажуулж байх

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,227.9 мянган төгрөгийн алдаа илэрч, 2,393.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

**Залруулсан алдаа:** Залруулсан алдаа байхгүй

#### 5.1 Төлбөрийн акт:

- **Илэрсэн алдаа:** Жилийн эцсийн тооллогоор хүнсний материалын үлдэгдэл 10 нэр төрлийн 2,393.3 мянган төгрөгийн хүнсний материал дутагдсан.
- **Шийдвэрлэсэн нь:** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөнд 2,393.3 мянган төгрөгийн акт тогтоов.

#### 5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

##### 5.3 Зөвлөмж:

**Илэрсэн алдаа:** Хүүхдийн хоолыг нормативт зардлаас илүү олгосон 1,834.6 мянган төгрөгөөр илүү зарцуулсан.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалт, Засгийн газрын 2019 оны 450, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллах

**Илэрсэн алдаа:** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 55 төрлийн 51,226.4 мянган төгрөгийн хөрөнгө элэгдээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

➤

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БҮРҮҮ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/Мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн
Хүүхдийн хоолыг нормативт зардлаас илүү олгосон	1	1,834.6					1	1,834.6			
Жилийн эцсийн тооллогоор хүнсний материалын үлдэгдэл 10 нэр төрлийн гурил, сүү, тэрэг, томьон, элсэн чихэр дутагдсан	1	2,393.3	1	2,393.3							
Анхны өртөө элгэлээрээ нөхсөн 0 үлдэгдэлтэй байгаа 55 нэр төрлийн 51,226,423.32 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг											
<b>Дүн</b>		<b>4,227.9</b>		<b>2,393.3</b>				<b>1,834.6</b>			

**АУДИТЫН ТАЙЛАН**

**ХЯНАСАН:**  
 АХЛАХ АУДИТОР  
 АУДИТЫН МЕНЕЖЕР:  
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

**ЦОЮУНСУВД**  
**Х.БОЛДБААТАР**  
**Д.БАТ-УНДРАА**

Огноо: 2025-02-13 5939376

**БОЛОВСРУУЛСАН:**  
 "ХААН СОЁМО АУДИТ" ХХК ГЭРЭЭТ АУДИТОР  
 Огноо: 2025-0-13

**Б.ЦЭРЭНДЭЖИД**